

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/203/НА-СТА-ТШЗ

Цахим
хуудас:
www.audit.mn

Хөвсгөл
аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Ц.Чагнаадорж

Утас: 99387994 Цахим хаяг: chagnaadorjts@audit.gov.mn

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь
салбарын захирал: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь
салбарын аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 08/108
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН СТАНДАРТ
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Д.БАТЦООЖ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Стандарт хэмжил зүйн газрын 2025 оны 09-р сарын 18-ний А/247 дугаар тушаалаар хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид компьютер, техник хэрэгсэл бусад тоног төхөөрөмж болох 26,456.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс нь аудитаар нийт 22,407.4 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 5,766.9 мянган төгрөгийн албан шаардлага, 16,640.5 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс нь Стандарт хэмжил зүйн газрын даргаар 2025 оны гүйцэтгэлгээний төлөвлөгөөг 12 хөтөлбөр, 44 арга хэмжээтэй батлуулж, 91 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	47,403,260.82	155,697,063.53
33	АВЛАГА	3,975,390.29	111,681,478.00
335	Бусад авлага	3,975,390.29	111,681,478.00
3351	Байгууллагаас авах авлага	3,975,390.29	111,681,478.00
35	БАРАА МАТЕРИАЛ	43,427,870.53	44,015,585.53
351	Түүхий эд материал	10,985,167.63	11,532,882.63
35110	Тусгай зориулалттай материал	00.00	547,715.00
35130	Эм боох материал	10,985,167.63	10,985,167.63
354	Хангамжийн материал	32,442,702.90	32,482,702.90
35410	Бичиг хэргийн материал	00.00	40,000.00
35470	Бусад хангамжийн материал	32,442,702.90	32,442,702.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	283,326,738.00	265,033,652.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	283,326,738.00	265,033,652.02
392	Биет хөрөнгө	230,085,904.76	211,876,152.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	112,358,848.00	112,358,848.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,127,971.92	-31,650,364.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78,600,432.00	78,600,432.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-78,600,432.00	-78,600,432.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	188,385,710.80	214,035,360.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-59,069,300.62	-97,974,213.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,198,986.50	22,198,986.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,660,368.00	-7,092,466.24
393	Биет бус хөрөнгө	53,240,833.24	53,157,500.00
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-316,666.76	-400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	53,157,500.00	53,157,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	330,729,998.82	420,730,715.55
413	Өглөг	13,761,987.75	29,144,340.20
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	9,786,597.46	11,346,159.64
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,975,390.29	6,946,310.56
4136	Бусад өглөг	00.00	10,851,870.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	10,851,870.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	316,968,011.07	391,586,375.35
51	Засгийн газрын хувь оролцоо	316,968,011.07	391,586,375.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	169,019,103.00	169,019,103.00
51101	Өмч: - төрийн	169,019,103.00	169,019,103.00
512	Хуримтлагдсан үр дүн	65,817,964.58	140,436,328.86
51210	Өмнөх үеийн үр дүн	65,817,964.58	65,817,964.58
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	74,618,364.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	82,130,943.49	82,130,943.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	330,729,998.82	420,730,715.55

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	377,703,797.00	912,272,630.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,934,120.00	912,272,630.82
120	Нийтлэг татварын бус орлого	103,934,120.00	265,072,064.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,934,120.00	265,130,093.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,347,120.00	238,481,478.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	587,000.00	26,590,586.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	273,769,677.00	648,702,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	272,769,677.00	648,702,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	272,769,677.00	648,702,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	324,307,613.16	837,654,466.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	324,307,613.16	837,654,466.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	294,062,413.16	836,152,733.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,387,613.63	530,741,166.80
210101	Үндсэн цалин	131,577,346.20	305,864,185.50
210102	Нэмэгдэл	55,029,953.17	149,323,063.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,438,000.00	53,143,803.10
210104	Урамшуулал	342,314.26	22,410,114.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,711,840.20	75,142,600.00
210201	Тэтгэврийн даатгал	16,931,068.40	53,412,845.26
210202	Тэтгэмжийн даатгал	1,974,893.45	5,307,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	967,646.23	3,153,854.74
210204	Ажилгүйдлийн даатгал	967,646.23	2,653,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,870,585.90	10,614,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,344,239.06	72,451,910.56
210301	Гэрэл, цахилгаан	3,944,523.67	10,654,508.50
210302	Түлш, халаалт	19,399,715.39	57,223,434.86
210303	Цэвэр, бохир ус	00.00	4,573,967.20
2104	Хангамж, бараа материалын зардал	3,030,270.00	14,824,370.00
210401	Бичиг хэрэг	654,000.00	8,140,830.00
210402	Тээвэр, шатахуун	641,550.00	3,638,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,210,350.00	2,046,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	404,370.00	998,400.00
2105	Нормативт зардал	6,017,690.00	11,506,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,067,760.00	7,221,700.00
210502	Хоол, хүнс	949,930.00	3,284,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	495,000.00	7,099,350.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	495,000.00	6,099,350.00
2107	Томилолт, зочны зардал	5,410,700.00	12,291,000.00
210702	Дотоод албан томилолт	5,410,700.00	12,291,000.00

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,192,100.00	66,963,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,300,000.00	64,468,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	1,080,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	122,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	225,100.00	1,293,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	587,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,472,960.27	45,132,735.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,560,000.00	1,190,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,912,960.27	43,942,735.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,245,200.00	1,501,733.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,245,200.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,245,200.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,501,733.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,501,733.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	53,396,183.84	74,618,164.28
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	53,396,183.84	74,618,164.28

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	377,116,797.00	887,183,778.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,347,120.00	238,481,478.00
120	Нийтлэг татварын бус орлого	103,347,120.00	238,481,478.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,347,120.00	238,481,478.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,347,120.00	238,481,478.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	273,769,677.00	648,702,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	272,769,677.00	648,702,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	272,769,677.00	648,702,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	295,144,699.82	887,183,778.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	295,144,699.82	887,183,778.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	264,899,499.82	777,200,566.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,057,917.63	530,741,166.80
210101	Үндсэн цалин	124,732,798.62	287,393,400.00
210102	Нэмэгдэл	55,026,953.51	149,323,063.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,438,000.00	53,143,803.10
210104	Урамшуулал	1,860,165.50	40,880,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,711,840.21	75,142,600.00
210201	Тэтгэврийн даатгал	16,572,860.37	53,412,845.26
210202	Тэтгэмжийн даатгал	1,937,789.46	5,307,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,362,966.73	3,153,854.74
210204	Ажилгүйдлийн даатгал	967,644.73	2,653,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,870,578.92	10,614,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,010,981.98	69,627,100.00
210301	Гэрэл, цахилгаан	3,944,523.67	7,668,204.52

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	15,066,458.31	57,078,117.66
210303	Цэвэр, бохир ус	00.00	4,880,777.82
2104	Хангамж, бараа материалын зардал	2,783,420.00	5,888,600.00
210401	Бичиг хэрэг	654,000.00	1,599,900.00
210402	Тээвэр, шатахуун	394,700.00	2,538,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,210,350.00	1,125,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	404,370.00	625,000.00
2105	Нормативт зардал	6,017,690.00	9,562,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,067,760.00	7,029,700.00
210502	Хоол, хүнс	949,930.00	1,532,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	495,000.00	5,794,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	495,000.00	4,794,500.00
2107	Томилолт, зочны зардал	5,657,550.00	12,291,000.00
210702	Дотоод албан томилолт	5,657,550.00	12,291,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,605,100.00	66,963,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,300,000.00	64,468,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	1,080,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	122,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	225,100.00	1,293,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,560,000.00	1,190,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,560,000.00	1,190,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,245,200.00	109,983,211.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,245,200.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,245,200.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	109,983,211.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	109,983,211.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	81,972,097.18	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	81,972,097.18	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	81,972,097.18	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	169,019,103.00	82,130,943.49	24,608,016.07	275,758,062.56
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	169,019,103.00	82,130,943.49	24,608,016.07	275,758,062.56
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	53,396,183.84	53,396,183.84
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	169,019,103.00	82,130,943.49	65,817,964.58	316,968,011.07

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	169,019,103.00	82,130,943.49	65,817,964.58	316,968,011.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	169,019,103.00	82,130,943.49	65,817,964.58	316,968,011.07
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	74,618,164.28	74,618,164.28
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	169,019,103.00	82,130,943.49	140,436,128.86	391,586,175.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	/Төгрөгөөр/	
				Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	800,598,400.00	777,200,566.80	23,397,833.20	97.08
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	800,598,400.00	777,200,566.80	23,397,833.20	97.08
210	Бараа, үйлчилгээний зардал	800,598,400.00	777,200,566.80	23,397,833.20	97.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	530,741,200.00	530,741,166.80	33.20	100.00
210101	Үндсэн цалин	287,393,400.00	287,393,400.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	150,498,400.00	149,323,063.70	1,175,336.30	99.22
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	51,968,500.00	53,143,803.10	(1,175,303.10)	102.26
210104	Урамшуулал	40,880,900.00	40,880,900.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,142,600.00	75,142,600.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	53,913,000.00	53,412,845.26	500,154.74	99.07
210202	Тэтгэмжийн даатгал	5,307,400.00	5,307,400.00	-	100.00
210203	ҮОМШӨ ний даатгал	2,653,700.00	3,153,854.74	(500,154.74)	118.85
210204	Ажилгүйдлийн даатгал	2,653,700.00	2,653,700.00	(0.00)	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,614,800.00	10,614,800.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,627,100.00	69,627,100.00	-	100.00
210301	Гэрэл цахилгаан	7,428,000.00	7,668,204.52	(240,204.52)	103.23
210302	Түлш, халаалт	56,411,100.00	57,078,117.66	(667,017.66)	101.18
210303	Цэвэр, бохир ус	5,788,000.00	4,880,777.82	907,222.18	84.33
2104	Хангамж, бараа материалын зардал	10,627,900.00	5,888,600.00	4,739,300.00	55.41
210401	Бичиг хэрэг	1,993,700.00	1,599,900.00	393,800.00	80.25
210402	Тээвэр (шатахуун)	4,005,500.00	2,538,400.00	1,467,100.00	63.37
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,840,900.00	1,125,300.00	1,715,600.00	39.61
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	293,100.00	-	293,100.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,494,700.00	625,000.00	869,700.00	41.81
2105	Нормативт зардал	13,278,800.00	9,562,200.00	3,716,600.00	72.01
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	9,975,000.00	7,029,700.00	2,945,300.00	70.47
210502	Хоол, хүнс	2,303,800.00	1,532,500.00	771,300.00	66.52
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2106	Эд хогшил худалдан авах	5,794,500.00	5,794,500.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	4,794,500.00	4,794,500.00	-	100.00

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	14,740,200.00	12,291,000.00	2,449,200.00	83.38
210702	Дотоод албан томилолт	14,740,200.00	12,291,000.00	2,449,200.00	83.38
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	79,456,100.00	66,963,400.00	12,492,700.00	84.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,835,300.00	64,468,400.00	11,366,900.00	85.01
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,080,000.00	1,080,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	214,800.00	-	214,800.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	473,500.00	122,000.00	351,500.00	25.77
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,100.00	-	33,100.00	-
210806	Мэдээллийн технологийн зардал	1,296,200.00	1,293,000.00	3,200.00	99.75
210807	Газрын төлбөр	214,600.00	-	214,600.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00	-	10,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	298,600.00	-	298,600.00	-
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	1,190,000.00	1,190,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,190,000.00	1,190,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	800,598,400.00	887,183,778.00	(86,585,378.00)	110.82
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	670,598,400.00	648,702,300.00	21,896,100.00	96.73
131001	Улсын төсвөөс санхүүжих	670,598,400.00	648,702,300.00	21,896,100.00	96.73
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	130,000,000.00	238,481,478.00	(108,481,478.00)	183.45
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,000,000.00	238,481,478.00	(108,481,478.00)	183.45
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	12.00	12.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36,716.8 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 1,627.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 7,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 23,207.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,881.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд 1.080.0 мянган төгрөгийн бусад бараа ажил үйлчилгээний зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид зардал гүйлгэн зарцуулсан. Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Сангийн сайдын 2023 оны 221 тушаалаар батлагдсан " ангилал шинэчлэн батлах тухай журам"-ын 2-р хавсралтын Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчигдсөн байна.

- Үнэт цаасны орлого зарлагыг хөөн шалгахад үлдэгдэл 547.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх, 5.1.5.хэмжигдэхүйц байх, зарчим, Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бүртгэгдээгүй байна.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй

3.2 Албан шаардлага

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс данснаас мэдээлэл сурталчилгааны сэтгүүл нийтлэх чиглэлээр хэвлэлийн компанитай гэрээ байгуулан 7 000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч үр дүн нь гараагүй ирүүлсэн материал байхгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4."Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Биет бус хөрөнгийн дансанд 1026.3м.кв, 1100м.кв нийт 2126 м.кв талбайтай 2 хэсэг 53 157.5 мянган төгрөгийн өртөгтэй газар бүртгэлтэй байх боловч улсын цахим бүртгэлийн нэгдсэн системд 1198 м.кв талбайтай 29 950.0 мянган төгрөгийн өртөгтэй газар эзэмших эрх бүртгэлтэй байна. Санхүүгийн тайланд 928 м.кв талбай буюу 23,207.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1.1 үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх, Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 10-р тогтоолын 7 дахь заалт зэргийг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн тооцооллыг шалгахад НД-ын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтээрх цалин 4 881.6 мянган төгрөгийн зөрүүтэй НД-ын тайланд үндсэн цалинг илүү тайлагнасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102.1.5.цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх, "Нийгмийн даатгалын тухай" хуулийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд цалингийн бодолтыг зөв гүйцэтгэх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн

аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Завсрын аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Залруулга	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгал, цалингийн хүснэгт зөрүүтэй	1	4,881.6					1	4,881.6		
Зориулалт бусаар зарцуулсан	1	7,000.0			1	7,000.0				
Орлогыг тайлагнаагүй.	1	38,671.0							1	38,671.0
Шатахууны тооцоолол дутуу	1	214.3	1	214.3						
Газрын хэмжээ зөрүүтэй	1	23,207.5			1	23,207.5				
Томиллолтоор ажилласан ажилтанд хоолны мөнгө давхардуулан олгосон.	1	1,781.0	1	1,781.0						
Нийт дүн	6	75,755.4	2	1,995.3	2	30,207.5	1	4,881.6	1	38,671.0

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үнэт цаасны орлого зарлагыг хөөн шалгахад үлдэгдэл 547.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.	1	547.7			1	547.7	1	547.7				
Санхүүгийн үр дүнгийн тайланд 1.080.0 мянган төгрөгийн бусад бараа ажил үйлчилгээний зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид зардал гүйлгэн зарцуулсан.	1	1,080.0			1	1,080.0	1	1,080.0				
Дүн	2	1,627,7			2	1,627,7	2	1,627,7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
4,881.6 мянган төгрөгийн зөрүүтэй НД-ын тайланд үндсэн цалинг илүү тайлагнасан байна.	1	4,881.6					1	4,881.6				
Мэдээлэл сурталчилгааны сэтгүүл нийтлэх чиглэлээр хэвлэлийн компанитай гэрээ байгуулан 7 000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч үр дүн нь гараагүй.	1	7,000.0	1	7,000.0								
Тухайн байгууллагын газрын хэмжээ зөрүүтэй	1	23,207.5			1	23,207.5		-				
Дүн	3	35,089.1	1	7,000.0	1	23,207.5	1	4,881.6				